



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 23 өдөр

Дугаар

A/682

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8/04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Баруун бүсийн өрсөлдөх чадварын чуулган 2019" арга хэмжээнд оролцсон Яамдын төлөөлөл, баруун 5 аймгийн удирдлага, үзэсгэлэн гаргасан 21 аж ахуйн нэгжид хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний зардалд 2 536 000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 2 536 000 төгрөг /хоёр сая таван зуун гучин зургаан мянган/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтийн 5.6 дахь заалт буюу Ногоон хөгжлийн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Г.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Б.ДҮГЭРЖАВ

Zax A/682 Ch

02 03369

Аймгийн Засаг даргын 2019 оны  
10 дугаар сарын 23-ны өдрийн  
А/682 дугаар захирамжийн хавсралт



“БАРУУН БҮСИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ЧУУЛГАН 2019”  
АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Хүндэт зочдод аймгийн брэнд бүтээгдэхүүнээр гарын бэлэг өгөх	ширхэг	10	40,000	400,000
2	Чуулганд оролцогчдын оройн зоог	ширхэг	80	26,700	2,136,000
Дүн					2,536,000

-oOo-